



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын Нөрөөт говь ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: *ӨМА-2023/32/НА-СТА-ОНА*

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Сүрэнжаргал
Утас: 70533552 Цахим хаяг: Surenjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 215

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэврэй сумын Нөрөөт говь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэврэй сумын Нөрөөт говь ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "... нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн, 20.2.5 "дансны өглөг, авлага ... баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасантай тус тус нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тус байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй,
- Авлага 0.3 сая төгрөг, өглөг 4.6 сая төгрөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилт, хүрэх түвшинг батлаагүй,

016020283

Асуудлыг онцолсон хэсэг

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр өссөн нь зайлшгүй шаардлагатай эм нөөцөлсөнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Нөрөөт говь ОНӨААТҮГ нь 103.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 93.4 сая төгрөгийг зардал гарган, 10.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэх толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	35,175.28	527,798.83
4	Дансны авлага	1,376.37	386,409.24
8	Бараа материал	14,338,456.52	24,253,850.80
12		-	-
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,375,008.17	25,168,058.87
14	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
15	Үндсэн хөрөнгө барилга	9,218,802.19	8,680,145.83
23	Биет бус хөрөнгө	1,083,249.96	760,249.92
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,302,052.15	9,440,395.75
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,677,060.32	34,608,454.62
31	Татварын өр	2,394,740.05	803,301.58
38	Бусад богино хугацаат өр төлбөр	2,446,118.06	3,822,172.01
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,840,858.11	4,625,473.59
49	Өр төлбөрийн нийт дүн	4,840,858.11	4,625,473.59
51	Өмч: а) төрийн	20,773,772.40	20,773,772.40
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-937,570.19	9,209,208.63
61	Эздийн өмчийн дүн	19,836,202.21	29,982,981.03
62	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,677,060.32	34,608,454.62

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	95,645,019.66	81,735,851.99
2	Борлуулалтын өртөг	74,220,652.62	78,276,567.17
3	Нийт ашиг	21,424,367.04	3,459,284.82
8	Бусад орлого	-	21,779,884.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	320,000.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	16,325,821.73	15,042,090.00
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	29,800.00	50,300.00
17	Бусад ашиг алдагдал	-270,000.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,018,745.31	10,146,778.82
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	5,018,745.31	10,146,778.82
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,018,745.31	10,146,778.82

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2021 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	20,773,772.40	-937,570.19	19,836,202.21
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	10,146,778.82	10,146,778.82
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,773,772.40	9,209,208.63	29,982,981.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	105,001,127.47	111,684,851.55
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	95,645,019.66	103,515,735.99
8	Бусад мөнгөн орлого	9,356,107.81	8,169,115.56
9	Мөнгөн зарлагын дүн (-)	105,783,041.91	111,192,228.00
10	Ажиллагчдад төлсөн	9,199,912.00	9,384,482.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,758,097.75	2,830,658.36
16	Татварын байгууллагад төлсөн	7,225,162.69	871,616.33
17	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
18	Бусад мөнгөн зарлага	29,800.00	50,300.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-781,914.44	492,623.55
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-781,914.44	492,623.55
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	817,089.72	35,175.28
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,175.28	527,798.83

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Дугаар	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
511001	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	-	81,735,851.99
521001	Татаас, санхүүжилтын орлого	-	21,779,884.00
611001	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		78,276,567.17
701013	Элэгдэл, хорогдлын зардал		861,656.40
701017	Тээврийн зардал		328,750.00
711001	Ажилчдын цалингийн зардал		11,307,298.00
711002	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал		1,289,931.68
711006	Шуудан холбооны зардал		227,272.46
711007	Мэргэжлийн үйлчилгээний зардал		100,000.00
711011	Ашиглалтын зардал		558,522.36
711017	Тээврийн зардал		368,659.10
741006	Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал		50,300.00

ГУРАВ АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, аудитын явцад 0.1 сая төгрөгийг залруулж, 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 23.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшинг боловсруулан батлуулах, авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулах талаар албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны талаар

Илрүүлэлт:

Шилэн дансанд эмийн үнэ 23.8 сая төгрөг илүү мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж:

Мэдээллийг үнэн зөв, бодитой, бүрэн мэдээлж хэвшүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй	1	0			1	0						
Сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилт, хүрэх түвшин байхгүй	1	0			1	0						
Тайлант онд 386,409.24 төгрөгийн авлага, 4,625,473.59 төгрөгийн өглөгийн тооцоо нийлсэн акт байгүй	1	5,011.8			1	5,011.8						

Дүн	3	5,011.8			3	5,011.8				
-----	---	---------	--	--	---	---------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд эмийн үнэ 23,873,935 төгрөг илүү мэдээлсэн.	1	23,873.9					1	23,873.9
Дүн	1	23,873.9					1	23,873.9